



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 162


Улаанбаатар хот

Ажлын хэсэг өөрчлөн
байгуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоол, Эрүүл мэнд, спортын яамны сайдын зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эх, хүүхдийн эрүүл мэндийн тухай хууль боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хуулийн төслийг 2015 оны IV улиралд багтаан шуурхай боловсруулж Сайдын зөвлөлд хэлэлцүүлэхийг Ажлын хэсэг /Д.Атармаа/-т үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Ганчимэг/-д даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2014 оны 130 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080551

Эрүүл мэнд, Спортын сайдын
2015 оны 04 сарын 24 өдрийн
169 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Д.Атармаа, Эрүүл мэнд, спортын дэд сайд
Дэд дарга	Р.Оюунханд, Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Нарийн бичгийн дарга:	С.Гончигсумлаа, Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
Гишүүд:	Н.Болормаа, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн
	С.Гантуяа, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн
	Ш.Мөнгөнцэцэг, Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн
	Ш.Энхтөр, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний Төвийн /ЭХТМҮТ/ ерөнхий захирал
	Т.Эрхэмбаатар, Эрүүл мэнд, спортын яамны Эх барих, эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн
	Х.Баавгай, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Гэр бүл, эмэгтэйчүүдийн хөгжлийн хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр)
	Д.Мөнхөө, Гал голомт үндэсний хөдөлгөөний тэргүүн (зөвшилцсөнөөр)
	Б.Алтанчимэг, Хүний хөгжил НҮЭМ/ЭРХ ТББ- уудын сүлжээний зохицуулагч (зөвшилцсөнөөр)

Эрүүл мэнд, Спортын сайдын
2015 оны 04 сарын 24 өдрийн
162 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Зорилго

Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгосноор эх, хүүхдийн эрүүл мэндийн байдлыг сайжруулах

Үйл ажиллагааны чиглэл

- Эх, хүүхдийн эрүүл мэндийн асуудал тусгагдсан одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудад дүн шинжилгээ хийх
- Засгийн газар, яам, агентлагаас гарсан эрх зүйн актуудад дүн шинжилгээ хийх
- Олон улсын хууль, эрх зүйн баримт бичгүүдийг судлах
- Эх, хүүхдийн эрүүл мэндийн хуулиар зохицуулах шаардлагатай тулгамдсан асуудлуудыг тодорхойлох
- Шинээр боловсруулах хууль ямар хуулиудад нийцэж боловсрогдох үндэслэл, мэдээллийг гаргах
- Эх, хүүхдийн эрүүл мэндийн хуулийн үзэл баримтлал, хуулийг боловсруулах
- Дагаж өөрчлөгдөх хуулийн жагсаалт, өөрчлөх зүйл, заалтыг тодорхойлох, өөрчлөн найруулах

Хүлээгдэж буй үр дүн

- Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих хууль, эрх зүйн орчин боловсронгуй болно.
- Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийн таатай орчин бүрдэнэ.
- Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ.

Хугацаа

2015 оны 04 дүгээр сараас 2015 оны IV улирал